



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 1/97

Улаанбаатар хот

Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны
бүрэлдэхүүн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Засгийн газрын "Дүрэм батлах тухай" 2019 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, тэднийг соён гэгээрүүлэх болон төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлаар дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг томилсугай.

Зөвлөлийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
З.Буянт

Гишүүд:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ч.Байгаль

25 дугаар хорооны Засаг дарга Ц.Алтангэрэл

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Ногоон байгууламжийн гүйцэтгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Баатарсүрэн

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Б.Саранцацрай

Нийгмийн хөгжлийн хэлтсийн Гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Батцэрэн

Нарийн бичгийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн албан хаагчийн ёс зүй, сургалт хариуцсан мэргэжилтэн Г.Однаран


2. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлын хүрээнд холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

1704.01.013

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллыг байгууллагын цалин урамшууллын журамд зааснаар олгосугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/53 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



С.ЭНХБАЯР